

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Гүйцэтгэлийн аудитын баг



**Өмч хөрөнгийн нэгдсэн судалгаагүй, хэрэгжүүлсэн ажлын тайлан
хангалтгүй, ажлын хариуцлага сулаас өмчид тавих дотоод
хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ ҮР ДҮНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД:ХОА-2021/118/-ШТА-ГА

Ховд хот
2021 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:99013699 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нарантуул
Утас: 70432545 Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn
Аудитор: Ц.Гантулга
Утас:7043-2545 Цахим хаяг: Gantulgats@audit.gov.mn
Аудитор: С.Оюунжаргал
Утас:7043-2545 Цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
Ерөнхий зүйл.....	6
БҮЛЭГ 1. Орон нутгийн өмч хөрөнгийн харилцаатай холбоотой заавар журмыг шинэчлээгүйгээс хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөө сул байна.....	7
1.1 Орон нутгийн өмч, хөрөнгийн харилцаанд хүчин төгөлдөр бус журмыг мөрдөж байна.....	7
1.2 Өмч хөрөнгийн хувийн хэргийн хөтлөлт бүрэн бус, баяжуулалт хийгдээгүй байна.....	7
1.3 Орон нутгийн өмч хөрөнгө зориулалтын дагуу бүрэн ашиглагдахгүй байна.....	8
1.4 Орон нутгийн өмчийн газар түрээслүүлсэн хөрөнгийн талаарх нэгтгэсэн судалгаагүй байна.....	9
1.5 Зарим өмч хөрөнгийг түрээслүүлэх гэрээг шинэчлээгүй байна.....	9-10
1.6 Түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.....	10
1.7 Өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэж биелэлтийг тооцсон талаарх нэгдсэн мэдээ тайлангүй байна.....	11
1.8 Дуудлага худалдааны орлогоос төрийн сангийн төлбөр тооцооны журмыг зөрчиж бэлнээр зарцуулсан байна.....	12
1.9 Дуудлага худалдааг ил тод нээлттэй, шударга зохион байгуулагдаагүй байна.....	12
1.10 Тайлант онд 271.5 сая төгрөгийн өмч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан, хөрөнгө бүртгэх зарим шийдвэрийг давхардуулан тогтоол гаргасан байна.....	13-14
1.11 Орон нутгийн өмчийн газар нь хөрөнгө данс бүртгэлээс хасах тухай саналыг аймгийн ИТХ-д уламжлан шийдвэрлүүлээгүй байна.....	15
БҮЛЭГ 2. Орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналтын чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлээгүй байна.....	15
2.1 Хөрөнгийн тооллого хийсэн талаарх ажлын тайлангүй, үр дүн хангалтгүй байна.....	15-17
2.2 Орон нутгийн байгууллагууд өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулаагүй, байгуулсан ч хийх ажлын төлөвлөгөөгүй байна.....	18
2.3 Орон нутгийн өмчийн газар нь хөрөнгийн нэгтгэлийг 1875.6 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэжээ.....	18-19
2.4 Хөрөнгийн цахим мэдээллийн систем ашиглагдах боломжгүй болжээ.....	19
2.5 Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хийгдээгүй байна.....	19-20
ДҮГНЭЛТ:	20
ЗӨВЛӨМЖ:	20-21
Холбогдох байгууллагын санал:.....	

Саналд өгсөн тайлбар:.....22-23

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмчийн
ҮАГ	Үндэсний аудитын газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
БИТ	Бизнес инкубатор төв
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Үндсэн хөрөнгийн 2020 оны хөдлөл, өөрчлөлт	8
Хүснэгт 2	2019-2020 оны түрээсийн орлогын тооцоо	10
Хүснэгт 3	Мянган угалзат ОНӨАТҮГ-ын түрээсийн орлогын тооцоо	10
Хүснэгт 4	Аймгийн ЗДТГ-ын орон сууцны судалгаа	11
Хүснэгт 5	2020 онд данс бүртгэлд тусгаагүй хөрөнгийн нэгтгэл	14
Хүснэгт 6	Хөрөнгийн эдийн засгийн ангилал буруу бүртгэсэн байгууллагын судалгаа	14
Хүснэгт 7	Данс бүртгэлээс хасагдаагүй хөрөнгийн судалгаа	15
Хүснэгт 8	Аймгийн Орон нутгийн өмчийн нэгтгэл	19

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Манхан сумын Соёлын төвийн Пургон автомашин	13
Зураг 2	Хот тохижуулах газрын ачигч ковш	13
Зураг 3	Хот тохижуулах газрын ланд дефендер	13
Зураг 4	ЭМТ-үүдэд ашиглалтгүй байгаа тоног төхөөрөмж	17
Зураг 5	Манхан сумын Соёлын төвийн хагарсан ваар	17

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Үндсэн хөрөнгийн бүтэц /сая.төгрөг/	6
Дүрслэл 2	Өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт /хувиар/	11

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1		
Хавсралт 2		

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/15 тоот “Аудитын сэдэв батлах тухай”, 2021 оны А/28 тоот “Аудитын төлөвлөгөө батлах тухай” тушаалын дагуу “Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтын үр дүн”-д Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	“Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтын үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➢ Орон нутгийн өмчийн харилцааг зохицуулах хууль, тогтоомжийг мөрдөж байгаа эсэх; ➢ Орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг аймгийн Орон нутгийн өмчийн газар, 17 сумын 158 орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраас санамсаргүй түүврийн аргаар сонгон авч тэдгээрийн үндсэн хөрөнгийн 2020 оны хөдлөл, өөрчлөлт, тайлант оны тооллогын бүртгэл, байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын тайлан, орон нутгийн өмчийн газрын мэдээ, тайлан, аймгийн эрх бүхий байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын хүрээнд хөдөөгийн 4 сумдад томилолтоор ажиллаж холбогдох горим сорилыг хэрэгжүүлсэн болно.
Аудитын хязгаарлалт	Аудитын хийх явцад Ковид-19 цар тахал орон нутагт бүртгэгдсэнтэй холбоотойгоор төсөвт болон орон нутгийн өмчийн байгууллагуудаар газар дээр очиж хөрөнгийн тулгалт хийх боломжгүй, цахим хэлбэрээр мэдээллийг авч ажилласан нь хүндрэлтэй байлаа. Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, нягтлан бодогч нар шаардлагатай баримт материалыг цаг хугацаанд гаргаж өгдөггүй, нэгдсэн судалгаа, мэдээлэл иж бүрэн бус, багийн ажлын уялдаа холбоо байхгүй, ажилдаа хариуцлагагүй хандаж байгаа нь аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын баримт материалаар хангагдах боломжгүй байсан нь аудитад бэрхшээлтэй байлаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, аймгийн ИТХ-ын сүүлийн 2 жилийн тогтоол шийдвэрийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул, аудитор Ц.Гантулга, С.Оюунжаргал, нар гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 28-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2020 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор хүлээн авч нэгтгэх бөгөөд аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, ҮАГ, Аймгийн ЗД, ИТХ, аймгийн Орон нутгийн өмчийн газар, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолоор аймгуудын ЗДТГ-ын бүтэц орон тоог шинэчлэн баталсны дагуу Орон нутгийн өмчийн газрыг аймгийн Засаг даргын 2016 оны А/500 тоот захирамжаар 12 орон тоотойгоор Өмчийн алба, худалдан авах ажиллагаа гэсэн 2 албатай баталсан байна. 2020 оны А/873 тоот захирамжаар Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны алба болгон бүтцийг өөрчилснийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн албан бичгээр А/500 тоот захирамжийг мөрдөж ажиллахыг зөвлөсөн байна.

Орон нутгийн өмчийн газар нь 2020 онд орон нутгийн өмч хөрөнгө тайлант оны эхэнд 227281.5 сая төгрөг байсан бол 38002.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 1706.5 сая төгрөгөөр хасагдаж оны эцэст 263557.4 сая төгрөгөөр нэгтгэж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, аймгийн ИТХ-аас хөрөнгө олж бэлтгэх, данс бүртгэлээс хасахтай холбоотой тогтоол шийдвэрүүдийг гарган, хөрөнгийн түрээсийн орлогоор 13.6 сая, авто тээврийн болон бусад хөрөнгийн дуудлага худалдааг зохион байгуулж 49.6 сая төгрөгийг Өмчийн сангийн дансанд төвлөрүүлжээ.

Дүрслэл -1

Орон нутгийн нийт хөрөнгийн барилга байгууламж 69.9 хувь, тээврийн хэрэгсэл 2.7 хувь, машин тоног төхөөрөмж 7.7 хувь, тавилга эд хогшил 3.7 хувь, зам гүүрийн байгууламж 4.4 хувь, түүх соёлын дурсгалт зүйл 1.1 хувь, номын фонд 0.5 хувь, дуусаагүй барилга байгууламж 0.6 хувь, батлан хамгаалахын тоног төхөөрөмж 0.02 хувь, программ хангамж 0.08 хувь, бусад үндсэн хөрөнгө 3.5 хувь, бусад биет бус хөрөнгө 5.6 хувийг эзэлж байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ӨМЧ ХӨРӨНГИЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ ЗААВАР ЖУРМЫГ ШИНЭЧЛЭЭГҮЙГЭЭС ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР НӨЛӨӨ СУЛ БАЙНА.

Орон нутгийн өмч, хөрөнгийн харилцаанд хүчин төгөлдөр бус журмыг мөрдөж байна.

1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйл 77¹-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах, хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглах, түрээслүүлэх, өмч хөрөнгийн хадгалалтад тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой журам зааврыг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 тоот тогтоолоор батлуулсан байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 271 тоот тогтоолоор "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх", 2019 оны 68 тоот тогтоолоор "Төрийн өмчит үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай", 2020 оны "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" заавар журмууд шинэчлэгдсэн байхад аймгийн Орон нутгийн өмчийн газар нь өмнөх мөрдөж байсан журам заавраа шинэчлээгүй хүчингүй болсон журам зааврыг ашигласаар байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 92 тоот тогтоолоор "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар", "өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх журам"-ыг боловсруулахдаа хүчингүй болсон 2009 оны 408 тоот тогтоолыг үндэслэн журмаа боловсруулсан байна.

Өмч хөрөнгийн хувийн хэргийн хөтлөлт бүрэн бус, баяжуулалт хийгдээгүй байна.

1.1.2 Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.18² дах заалт, Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 180 тоот тушаалаар "Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам" батлагдсан ч төсөвт болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд Барилгын тухай хуулийн 46.1.2³-д заасны дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх, 46.1.12⁴-д заасны дагуу баяжилт хийхээр тусгагдаж орон нутгийн өмчийн байгууллагууд барилгын хувийн хэрэгт хөрөнгө оруулалт, их засвар, тайлант онд байгуулсан элэгдэл, 2018 оны дахин үнэлэгдсэн талаарх мэдээллийн баяжуулалтыг хийгээгүй, 35 дугаар зүйлийн 35.1.4⁵-д заасны дагуу паспортжуулаагүй байна. Аудитаар түүвэрт хамрагдсан байгууллагаас Манхан, Зэрэг, Чандмань, Цэцэг сумдын ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв, Манхан Спорт цогцолбор зэрэг байгууллагууд дээрх журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Мөн хууль журамд заасны дагуу баяжуулалт хийгдээгүйгээс УТХО, ОНХО, ОНХС болон бусад эх үүсвэрээс санхүүжигдсэн төсөл арга хэмжээ нь хэдэн онд хэрэгжсэн, хөрөнгө

¹ Орон нутгийн өмчийн талаарх иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

² барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмыг батлах;

³ энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх;

⁴ барилгын ашиглалтын хугацаанд барилга байгууламжийн баримт бичгийг баяжуулж, хадгалах;

⁵ тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах;

зарцуулсан эсэх талаарх мэдээллүүдийг авах боломжгүй байгаа нь уг хөрөнгөд ашиглалтын явцад төсвийн хэчнээн хэмжээний хөрөнгийг зарцуулсан талаарх бодит мэдээллийг авах боломж хангагдахгүй байна.

Орон нутгийн өмч хөрөнгө зориулалтын дагуу бүрэн ашиглагдахгүй байна.

1.1.3 Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2020 онд 158 байгууллагын 265443.7 сая төгрөгийн хөрөнгийг нэгтгэсэн талаарх мэдээллийг аудитын байгууллагад ирүүлсэн. Аудитын тулгалтаар 161 орон нутгийн байгууллагын 263577.5 сая төгрөгийн өмч хөрөнгө ашиглагдаж, ТӨБЗГ-т 1875.6 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэж хүргүүлсэн байна. *Хүснэгт -1*

Хөрөнгийн ангилал	2020 оны эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	2020 оны эцсийн үлдэгдэл
Барилга байгууламж	159,622.6	25,240.3	426.2	184,436.8
Тээврийн хэрэгсэл	7,041.7	887.4	656.0	7,273.1
Машин тоног төхөөрөмж	18,250.6	2,458.9	310.0	20,399.5
Тавилга эд хогшил	8,275.3	1,518.3	158.5	9,635.1
Зам гүүрний байгууламж	5,334.4	6,514.4	44.1	11,804.8
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	56.6	8.3		64.9
Түүх соёлын дурсгалт зүйл	2,763.2	39.8	0.0	2,803.0
Дуусаагүй барилга байгууламж	1,441.1	184.3	60.0	1,565.5
Номын фонд	1,285.7	113.8	36.8	1,362.7
Бусад үндсэн хөрөнгө	8,209.8	959.5	11.6	9,157.7
Программ хангамж	189.1	13.0	3.2	198.8
Бусад биет бус хөрөнгө	14,811.5	59.3		14,870.8
Бусад хөрөнгө		5.0		5.0
ДҮН	227,281.5	38,002.4	1,706.5	263,577.5

1.1.4 Сум байгууллагуудын нягтлан бодогчдоос авсан судалгаагаар орон нутгийн өмч хөрөнгийн данс бүртгэлд байгаа хөрөнгийн 11488.1 сая төгрөгийн буюу 4.3 хувь нь ашиглалт хангалтгүй байна. /Эх сурвалж: ашиглагч байгууллагуудын нягтлан бодогчоос авсан судалгаагаар/ Үүнд:

- Алтай сумын хуучин төвд байрлах 84.1 сая төгрөгийн ЗДТГ-ын барилга, 4 айлын орон сууц, улаан булан склад ашиглалтгүй,
- Цэцэг сумын Хөшөөт багийн хуучин 103.8 сая төгрөгийн балансын үнэтэй цэцэрлэгийн барилга ашиглалтгүй,
- Үенч сумын ЗДТГ-ын 1950 онд ашиглалтад орсон “шар байр”, ЕБС-ийн 1954 онд орсон “бага сургуулийн хичээлийн байр”, 1955 онд ашиглалтад орсон “шавар байр”, ЭМТ-ийн 2011 оны 2 ширхэг “мотоцикл”-ийг худалдан борлуулсан, 1963 оны автомашины граш зэрэг данс бүртгэлд байгаа ч бодитой оршин байхгүй, барилгыг холбогдох байгууллага албан тушаалтны шийдвэргүйгээр буулгаж устгасан,
- Буянт сумын ЗДТГ-ын данс бүртгэлд Цагдаагийн газраас балансаас балансад шилжүүлсэн 13.9 сая төгрөгийн балансын үнэтэй 3.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг бүртгэлд тусгаагүй,
- Орон нутгийн байгууллагуудад 8793.4 сая төгрөгийн 784 ширхэг худаг данс бүртгэлд байгаа боловч 1595.7 сая төгрөгийн 228 ширхэг худаг ашиглах боломжгүй эвдэрсэн,
- Судалгаагаар 583 ширхэг 7273.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл байгаагаас 314.1 сая төгрөгийн 70 ширхэг тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон,

- Орон нутгийн байгууллагуудын данс бүртгэлд байгаа 11 сумын 14 ширхэг 833.9 сая төгрөгийн халууны усны барилгын ашиглалт хангалтгүй,
- Эрдэнэбүрэн, Цэцэг, Чандмань, Дуут, Ховд, Буянт сумдын ЗДТГ-т данс бүртгэлд байгаа 408.6 сая төгрөгийн БИТ-ын барилгуудын ашиглалт хангалтгүй,
- Зэрэг сумын ЕБС-ийн 2012 онд ашиглалтад орсон 6.5 сая төгрөгийг үнэтэй гадна биеийн тамирын талбайг данс бүртгэлээс хассан тухай шийдвэргүй, 2020 онд ОНХО-аар 61.7 сая төгрөгийн өртгөөр хийгдсэн боловч гэрээний дагуу ажлаа бүрэн хийж өгөөгүй холбогдох байгууллагад уламжилсан ч шийдвэрлэгдээгүй,

1.1.5 Зарим байгууллагуудын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж шаардлагатай байгууллагуудад шилжүүлэн ашиглуулж хөрөнгийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

- Дуут сумын ЗДТГ-ын 41.8 сая төгрөгийн балансын үнэтэй байсан хуучин конторын барилгыг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 44.1 сая төгрөгөөр засвар хийгдэж одоо ЭМТ нь үйл ажиллагаа явуулж байна,
- 2020 онд УТХО-аар баригдсан Цэцэг сумын халуун усны барилгыг боломжийн хэмжээнд явагдаж байхад Чандмань сумын халуун усны барилга одоог хүртэл ашиглалтад ороогүй байна.

Орон нутгийн өмчийн газар түрээслүүлсэн хөрөнгийн талаарх нэгтгэсэн судалгаагүй байна.

1.2.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2⁶, 77⁷ дугаар зүйлд зааснаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 90 тоот тогтоолоор “Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслэх журам”, 91 тоот тогтоолоор “Түрээсийн гэрээний загвар баталж, төлбөрийн доод үнэ”-ийг тогтоон баталжээ. Тус журмын 5.1⁸-д заасны дагуу нийтэд мэдээлэл ил тод байрлуулсан эсэх нь тодорхой бус, 5.2⁹-д заасны дагуу аймгийн хэмжээнд орон нутгийн өмч хөрөнгийг түрээслүүлэхдээ түрээслэгчийг сонгон шалгаруулах талаар Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар ажлын хэсэг томилоогүй байна.

Орон нутгийн өмчийн газарт түрээсийн гэрээ байгуулан түрээслүүлж байгаа өмч хөрөнгө, түрээсэлж байгаа талбайн хэмжээ, сарын болон жилийн төлбөрийн хэмжээ, нийт хэчнээн сум байгууллагын хөрөнгийг түрээсэлж байгаа талаар нэгтгэсэн дэлгэрэнгүй судалгааг аудитын явцад ирүүлсэнгүй.

1.2.2 Аудитын явцад орон нутгийн өмчийн байгууллагуудаас өмч хөрөнгийг түрээсэлсэн талаарх гэрээг авч тулгахад хөрөнгийг түрээслүүлэх гэрээг байгуулахдаа түрээслэх талбайн хэмжээ тодорхой бус, гэрээний дугааргүй, гэрээний эхлэх болон дуусах хугацаагүй, сунгалт хийгээгүй, гэрээний хугацаа дууссан зэрэг дутагдал байна.

Зарим өмч хөрөнгийг түрээслүүлэх гэрээг шинэчлээгүй байна.

1.2.3 Орон нутгийн өмч хөрөнгийг түрээслэгч байгууллага нь журмын 5.4¹⁰-д заалтын дагуу түрээслэх талбай, сард төлөх төлбөрийн хэмжээг түрээслэгчтэй тохиролцон гэрээг харилцан адилгүй байгуулсан байна. Тухайлбал: Аймгийн ЗДТГазар нь Ховдын толь

⁶ Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ.

⁷ Орон нутгийн өмчийн талаарх Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх

⁸ Хөрөнгө түрээслүүлэгч бусдад түрээслэх хөрөнгийн талаар мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр нийтэд ил тод зарлана.

⁹ Түрээслэгчийг сонгон шалгаруулахаар аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулна. Ажлын хэсэгт ба байгууллагын санхүүгийн ажилтан болон өмч хамгаалах зөвлөлийн төлөөллийг заавар оролцуулна.

¹⁰ Нийтэд зарласан хөрөнгө түрээслүүлэх тухай зарын дагуу хөрөнгө түрээслэхээр ирүүлсэн саналыг ажлын хэсэг ирүүлсэн дарааллаар бүртгэн хүлээн авч 2 ба түүнээс дээш сонирхогч санал ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалт хийж төсвийн захирагчид тэмдэглэлээр танилцуулснаар төсвийн захирагч гэрээ байгуулна. Нэг сонирхогч санал ирүүлсэн тохиолдолд тухайн байгууллагын төсвийн захирагч тус журмын 3.1, 3.2 дах заалтыг хангуулан түрээслэгчтэй тохиролцон түрээсийн гэрээ байгуулна.

сонины газартай сард 21.0 буюу жилд 252.0, Ховдын мэдээ сонины газраас сард 50.0 мянган буюу 600.0 мянган төгрөг авах тусгасан байна.

1.2.4 Түрээсийн гэрээний журмын 6.1¹¹, 6.2¹² дах заалтын дагуу орон нутгийн өмчийн газарт түрээслэгч байгууллага нь 15 хоногийн дотор бүртгүүлэхээр тусгасан ч бүртгүүлснийг нотлох баримтгүй, энэ талаар нарийн судалгаа бүртгэл тооцоогүй, журмын 6.5¹³-д заасны дагуу түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд тооцох алданги тооцохоор заасан ч хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал: Зэрэг, Цэцэг, Дарви, Мөст сумдад 2020 онд УТХО-аар шинээр халуун усны барилга баригдаж ашиглалтад орсон боловч түрээсээр эзэмшүүлэх гэрээгүй,

1.2.5 Сумдын ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд байгаа халуун ус, хог тээврийн автомашин, худгийн барилгыг ямар нэгэн гэрээгүйгээр хувь хүн эзэмшиж ашиглуулж байгаа ч жишиг болохуйц орон нутгийн өмчийг түрээслэн орлого төвлөрүүлсэн төсвийн захирагч байхгүй байна.

Түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

1.2.6 ТӨБЗГ-ын 2018 оны 293 тоот тогтоолын 4.2¹⁴, “Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ын 3.5¹⁵-д заасны дагуу түрээсийн орлогын 30 хувийг төвлөрүүлэхээр тусгажээ.

Орон нутгийн өмч хөрөнгийг түрээслүүлсний түрээсийн орлогоор 2019-2020 онд 210.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж ногдох орлогоос орон нутгийн өмчийн санд 35.3 сая төгрөгийг дутуу төвлөрүүлжээ.

Хүснэгт-2

он	түрээсийн орлогын дүн	төвлөрүүлэх 30 %	Өмчийн санд төвлөрүүлсэн дүн	Өмчийн санд төвлөрүүлээгүй орлогын дүн
2019 он	107,047.7	32,114.3	12,840.2	19,274.1
2020 он	98,418.6	29,525.6	13,492.4	16,033.2
ДҮН	205,466.3	61,639.9	26,332.6	35,307.3

1.2.7 2019-2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн өмчийн газар 3453.5, Жаргалант сумын ЗДТГ-т 918.0, Шим ус ОНӨААТҮГ 1915.5, Буянт сумын ЕБС 3179.3, Булган сумын 2 дугаар ЕБС 200.0 мянган төгрөгийг хөрөнгийн түрээсийн орлогын 30% болох 16430.9 мянган төгрөгийг төвлөрүүлээгүйд төлбөрийн акт бичигджээ.

1.2.8 Мянган Угалзат ОНӨТҮГ-ын нийт орлогын 8.7-13.2 хувийг аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүст байр түрээслүүлсний орлогоос бүрдүүлдэг, Ковид-19 цар тахлын улмаас Дуутын Нэвт амралт сувиллын газар, Хүүхдийн тоглоомын паркууд үйл ажиллагаа явуулаагүйгээс орлогын төлөвлөгөө тасарч, эдийн засгийн хомсдол үүссэнээс 10189.5 мянган төгрөгийн түрээсийн орлогыг орон нутгийн санд төвлөрүүлэх боломжгүй болжээ.

Хүснэгт-3

¹¹ Орон нутгийн өмчийн байгууллага нь түрээслүүлж буй хөрөнгийн тухай мэдээллийг төрийн болон орон нутгийн өмчийн цахим системд бүрэн оруулна.

¹² Түрээслүүлэгч түрээслэгчтэй түрээсийн гэрээ байгуулснаас хойш 15 хоногт багтаан орон нутгийн өмчийн албанд гэрээг бүртгүүлнэ.

¹³ Түрээсийн төлбөрийг тогтоосон хугацаандаа төлөөгүй болон зохих дансанд төвлөрүүлээгүй бол хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож алданги ногдуулна

¹⁴ Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр ашиглаж буй этгээдийн түрээсийн төлбөр болон улсын төсөвт төвлөрүүлэх, орлогыг гэрээний дагуу тухай бүр бүрэн төлүүлэх арга хэмжээ авах

¹⁵ Түрээслүүлэгч түрээсийн төлбөрийн 30 хувийг төлбөр орсноос хойш ажлын 5 өдрийн дотор төсөвт төвлөрүүлнэ

он	түрээсийн орлогын дүн	төвлөрүүлэх 30 %	Өмчийн санд төвлөрүүлсэн дүн	Өмчийн санд төвлөрүүлээгүй орлогын дүн
2019 он	14,451.8	4,335.5		4,335.5
2020 он	19,513.2	5,854.0		5,854.0
ДҮН	33,965.0	10,189.5	-	10,189.5

1.2.8 Албаны орон сууц эзэмшүүлэх журам, албаны орон сууц эзэмшигчтэй хийх гэрээний загварыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 сарын 10-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталж мөрдөж байгаад 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 127 тоот тогтоолоор уг журмыг өөрчлөн баталжээ. Уг журмын 3 дугаар зүйлийн 3.1-д орон сууцыг дараах байдлаар албан тушаалаар нь байгууллагад хуваарилан эзэмшүүлэхээр тусгажээ.

Хүснэгт-4

Д/д	Орон сууцны нэр	Өрөөний тоо	Хэмжээ/м2/	Эзэмших байгууллага	Оршин суух албан тушаалтан
1	Домбот хотхоны 2 дугаар 48 айл	3	67,21	Аймгийн ЗДТГазар	Аймгийн Засаг дарга
2	2 дугаар 80 айл	2	30	Прокурорын газар	Аймгийн Прокурор
3	2 дугаар 80 айл	2	30	Шүүхийн шинжилгээний алба	Албаны дарга
4	3 дугаар 36 айл	2	24.4	Аймгийн шүүх	Ерөнхий шүүгч
5	Даатгалын 12 айл	2	32.6	Цагдаагийн газар	Газрын дарга
6	ЭСБА-ийн 80 айл	2	45.7	Аймгийн ИТХ	Аймгийн ИТХ-ын дарга
7	ЭСБА-ийн 80 айл	1	36.7	Аймгийн ЗДТГ	Онцгой шаардлагын улмаас ирж ажиллаж байгаа мэргэжилтэн
8	ЭСБА-ийн 80 айл	1	36.7	Тагнуулын газар	Тагнуулын газрын дарга

Аудитын явцаас хянахад ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолын нэгдүгээр хавсралтын заалтыг зөрчиж аймгийн засаг даргын албан тушаалын байранд аймгийн Ерөнхий прокурор, аймгийн прокурорын албан тушаалын байрыг цагдаагийн газар эзэмшдэг, аймгийн ИТХ-ын даргын албан тушаалын байр, аймгийн ЗДТГ-ын эзэмшилд байх Онцгой шаардлагын улмаас урилгаар ирж ажиллах мэргэжилтний байрыг аймгийн БОЭТ-ийн эмч нарт эзэмшүүлж байгаа, тогтоолын 2 дугаар хавсралтаар албаны орон сууц эзэмшүүлэх загвар гэрээг баталсан ч тухайн эзэмшигч нартай гэрээг байгуулсан, өөрчилсөн, сунгасан, эзэмшигч, эзэмшүүлэгчийн гэрээг дүгнэсэн тодорхой баримт материалгүй өдий хүрчээ.

Өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэж биелэлтийг тооцсон талаарх нэгдсэн мэдээ тайлангүй байна.

1.2.9 Төрийн болон орон өмчийн тухай хуулийн 11 дүгээр 11.1¹⁶, 11.2¹⁷ дахь заалтууд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 276 дугаар тогтоол “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 92 дугаар тогтоолоор Орон нутгийн өмчийн хуулийн этгээдтэй байгуулах “орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар”, “Орон нутгийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх журам”-ыг батлахдаа хүчингүй болсон тогтоолыг үндэслэл болгосон байна.


Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүд өөрийн хариуцсан сум, байгууллагуудын өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэсэн боловч бодитой дүгнэсэн нь тодорхой бус, түүний талаар авч хэрэгжүүлэн арга хэмжээний мэдээлэлгүй байна.

Аудитын явцад орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүдээс өмч эзэмшүүлэх гэрээ дүгнэсэн 127 байгууллагын материалыг авч нэгтгэхэд 90.5 хувьтай дүгнэж, 34 байгууллагын гэрээг дүгнээгүй, орон нутгийн өмчийн газарт нэгтгэсэн баримт, материал ирүүлээгүй болно.

Дүрслэл -2

¹⁶ Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах

¹⁷ Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах



Дуудлага худалдааны орлогоос төрийн сангийн төлбөр тооцооны журмыг зөрчиж бэлнээр зарцуулсан байна.

1.2.10 ТБОНӨ-ийн тухай хуулийн 38¹⁸ дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 93 тоотор “орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ыг батлуулан мөрдөж байгаа ч, хууль эрх зүйн актыг ТӨБЗГ-ын 2019 оны 268 тоот тогтоолоор шинэчилсэн байна. Уг журмын 2.11.1¹⁹-д заасны дагуу худалдах доод үнэ тогтоох талаар тус газрын даргын тушаал шийдвэр гаргаагүй, үнэ тогтоосон талаар нотлох баримт материал аудитын явцад ирүүлээгүй, тухайн заалтыг мөрдөн ажиллаагүй, худалдах доод үнийг бодитой тогтоосныг нотлох боломжгүй байна.

1.2.11 2019-2020 онуудад 44 тээврийн хэрэгслийн дуудлага худалдаагаар 2019-2020 онд 118.4 сая, 22 барилга байгууламжийг худалдан борлуулахаар дуудлага худалдаа зохион байгуулагдаж 6 барилга байгууламжийг худалдах, худалдан авах гэрээ байгуулагдсанаас Цэцэг сумын Хөшөөт багийн цэцэрлэгийн барилгыг авсан оролцогч нь гэрээ байгуулахаас татгалзсан, Өмчийн сангийн 100160051424 тоот дансанд 19.2 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

1.2.12 Дуудлага худалдааны орлогыг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.2²⁰, 23.9.2²¹, Төрийн сангийн төлбөр тооцооны журмын 2.6²² дах заалтуудыг мөрдөөгүй орлогыг орон нутгийн өмчийн сангийн санд төвлөрүүлээгүй 5.1 сая төгрөгийг бэлнээр авч 2019 онд 1.2 сая төгрөгөөр 3 үйлдэлт принтер худалдан авч орлогод аваагүй данс бүртгэлд тусгаагүй, 3.9 сая төгрөгийг байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5²³ дах заалтыг зөрчиж байна.

Дуудлага худалдааг ил тод нээлттэй, шударга зохион байгуулагдаагүй байна.

1.2.12 Аудитын явцад орон нутгийн өмчийн газраас зохион байгуулсан тээврийн хэрэгсэл барилга байгууламжийн дуудлага худалдааг түүвэрчлэн хянахад дараах зөрчил илэрлээ.

- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас ЭМГ-ын 4463 УНЛ дугаартай Парадо-76 маркийн автомашиныг дуудлага худалдаанд оруулах 2020 оны 115 тоот гарч, дуудлага худалдаа 5 дугаар сарын 25-нд зохион байгуулагдаж 25 оролцогч оролцсон ч уг тээврийн хэрэгсэл хоёр өөр улсын дугаартай гэсэн шалтгаанаар зогсоосон байна. 2020 оны 12 дугаар сарын 09-нд дээрх тээврийн хэрэгслийг Нутгийн удирдлагын ордонд “нээлттэй дуудлагын худалдаа зарлах тухай” 215 тоот тогтоол гарчээ. Гэвч уг дуудлага худалдаа хэзээ хаана хэдэн сарын хэдний

¹⁸ Дуудлага худалдаа

¹⁹ Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн худалдах доод үнийн саналыг мэргэжлийн байгууллагын мэргэжилтэнг оролцуулан Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг тогтооно

²⁰ төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого;

²¹ орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

²² “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”

²³ 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

өдөр зохион байгуулагдсан талаарх нотлох баримт материал Орон нутгийн өмчийн газрын санхүүгийн баримтад хавсаргагдаагүй, ахлах мэргэжилтэн нь ЭМГ-т дуудлага худалдаа зохион байгуулах тухай албан тоот хүргүүлсэн гэсэн аман тайлбар өгсөн.

Орон нутгийн өмчийн газрын 100160051424 тоот дансанд уг машины дуудлага худалдааны үнэ 2020 оны 12 сарын 22-нд 875.0, 25-ны өдөр 3025.0 нийт 3900.0 мянган төгрөгийг хувь иргэн төлжээ.

Аудитын явцад ЭМГ-т дээрх дуудлага худалдааны талаар нэмэлт тайлбар авах тухай албан тоот хүргүүлж, ЭМГ-ын 421 тоот албан бичгээр манай байгууллага дээр дуудлага худалдаа зохион байгуулагдаагүй, Прадо-76 автомашиныг аймгийн Орон нутгийн өмчийн газар 5 сард авч явсан болно гэсэн хариу ирүүлсэн.

- Манхан сумын Соёлын төвийн 2007 оны “Пургон” маркийн авто машин нь 2018 оны 87 тоот тогтоолоор нээлттэй дуудлага худалдаа зарлагдаж анхны дуудлага худалдааны талаар гомдол гаргасан тул дуудлага худалдааг хойшлуулж, 2020 оны 116 тоот тогтоолоор дахин дуудлага худалдаагаар оролцогч ирээгүй байна. Уг тээврийн хэрэгсэл албан ёсоор үнэлж албажуулсан бичиг баримтгүй, лац, ломбогүй Соёлын төвийн эрхлэгчийн хашааны гражид хадгалагдаж, тээврийн хэрэгслийн хувьд 4 дугуй хуучирч элэгдээгүй, өнгө үзэмж сайтай байдалтай,



Зураг-1

- Дуудлага худалдаанд зохион байгуулагдаад оролцогч ирээгүйгээс Хот тохижуулах газрын 5.0 сая төгрөгийн үнэтэй ачигч ковш, мотор кроп үгүй, шилнүүд хагархай, Хот тохижуулах газрын хашаанд,
- Орон нутгийн өмчийн газрын эзэмшлийн “Ланд дефендер” тээврийн хэрэгслийг 1.0 төгрөгөөр дуудагдаж оролцогч ирээгүй, шилнүүд хагархай, кропинд түлхүүр гацсан сэлбэг материал олдохгүй тул оролцогч ирэхгүй байна гэсэн тайлбартай айлын хашаанд тус тус хадгалагдаж байна.
- 2019 онд Цагдаагийн газрын төв захын доод талд байрлах 6518.1 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй кобины дуудлага худалдаанд 1 оролцогч санал ирүүлсэн нь журмын 2.10.3 в²⁴ гэсэн заалт мөрдөгдөөгүй байхад уг барилгыг борлуулан сангийн дансанд төвлөрүүлсэн байна.



Зураг-2



Зураг-3

Тайлант онд 271.5 сая төгрөгийн өмч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан, хөрөнгө бүртгэх зарим шийдвэрийг давхардуулан тогтоол гаргасан байна.

1.3.1 2020 онд аймгийн Орон нутгийн өмчийн газарт орон нутгийн төсөвт, орон нутгийн өмчит байгууллагаас 38002.4 сая төгрөгийн хөрөнгө орлого авч бүртгэх талаар ирүүлсэн хүсэлт албан тоотыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны тогтоол шийдвэрүүдийг гаргасан байна.

Өмч хөрөнгө бүртгэх тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас гаргасан тогтоол нь нэг хөрөнгө дээр байгууллагын нэрийг давхардуулсан зөрчил байна. Үүнд:

- Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн 29.5 сая төгрөгийн сантехникийн засвар,

²⁴ Дуудлагын худалдаанд нэг ч этгээд ирээгүй, эсхүл хоёроос доош этгээд ирсэн, худалдах доод үнээс дээш үнийн санал гараагүй бол дуудлага худалдааг явагдаагүйд тооцон, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ

- Булган сумын 3719.6 сая төгрөгийн өртөгтэй Минжит Булган спорт цогцолборын барилга байгууламж, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгө бүртгэх тухай шийдвэр,

1.3.2 Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалаар “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын 4-д заасны дагуу шинээр байгуулагдсан байгууллагын газрыг үнэлж данс бүртгэлд бүртгээгүй байна. Тухайлбал: Булган сумын таван цагираг цогцолборын 8322.2 м², Жаргалант сумын 16 дугаар цэцэрлэгийн 4172 м² газрууд эзэмших гэрчилгээтэй боловч 24988.4 мянган төгрөгөөр үнэлж данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрлээ.

Тайлант онд УТХО болон аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгө данс бүртгэлд тусгах тухай ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэр гарсан ч зарим байгууллагууд хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Хүснэгт-5

д/д	сум	байгууллагын нэр	ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол		хөрөнгийн нэр	дүн
			он, сар, өдөр	дугаар		
1	Эрдэнэбүрэн	ЗДТГ	2020.12.09	212	Dell -I 5 компьютер	1,857.1
2	Буянт	ЗДТГ	2020.12.09	212	Dell -I 5 компьютер	1,857.1
3	Жаргалант	Хот тохижуулах	2020*01*16	6	услалтын систем	19,231.8
4	Жаргалант	Хот тохижуулах	2020*01*16	6	Баруун бүсийн Соёмбот цамхаг	59,885.0
5	Дөргөн	ЗДТГ	2020*01*16	22	Хүнхийн бөгс худаг /Сээр баг/	17,500.0
6	Дөргөн	ЗДТГ	2020*01*16	28	Шар дал /Аргалант баг/	19,845.3
7	Дарви	ЗДТГ	2020*01*16	28	Эрээний худаг /Булаг баг/	19,845.3
8	Үенч	ЗДТГ	2020*11*09	145	гэрэлтүүлэг	9,000.0
9	Үенч	ЗДТГ	2020*11.09	145	Ёслол хүндэтгэлийн гэр	11,968.3
10	Алтай	Цэцэрлэг	2020*12*09	200	гадна биеийн тамирын талбайн тохижилт	17,867.5
11	Жаргалант	ЗДТГ	2020*12*09	197	Буянт голын модон гүүр - 2 ширхэг	9,986.0
12	Жаргалант	ЗДТГ	тогтоолгүй		Тунгалаг буянт дууны хөшөө	15,000.0
13	Жаргалант	11 дүгээр цэцэрлэг	2020*12*30	282	гадна тохижилт	6,000.0
14	Мянган Угалзат	ОНӨТҮГазар	тогтоолгүй		ЦТБ-ийн барилгын өргөтгөл	61,669.6
НИЙТ ДҮН						271,513.1

Хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа хөрөнгийн ангилал буруу сонгон доорх байгууллагууд 172.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.

Хүснэгт -6

д/д	сумын нэр	байгууллагын нэр	хөрөнгийн нэр	дүн	ангилал
1	Манхан	ЗДТГ	цэвэр ус, дулааны шугам	14,500.0	Тоног төхөөрөмж
2	Манхан	ЗДТГ	бохир усны шугам	9,800.0	Тоног төхөөрөмж
3	Манхан	Сургууль	мотоцикл	2,000.0	Тоног төхөөрөмж
4	Булган	ЗДТГ	Торгууд нутаг дууны хөшөө	2,500.0	барилга байгууламж
5	Булган	ЗДТГ	Хөшөө/Б,Бадам,Э,Шилэг/	120,000.0	барилга байгууламж
6	Булган	ЗДТГ	Хэлмэгдэгсдийн хөшөө	5,000.0	барилга байгууламж
7	Булган	ЗДТГ	Бадамын хөшөө	5,000.0	барилга байгууламж
8	Дарви	ЭМТөв	нурууны массажны аппарат	450.0	барилга байгууламж
9	Дарви	ЭМТөв	булчин чангалагч аппарат	425.0	барилга байгууламж
10	Дарви	ЭМТөв	хурдан гүйгч аппарат	450.0	барилга байгууламж
11	Дарви	ЭМТөв	савлагч аппарат	425.0	барилга байгууламж
12	Буянт	ЗДТГ	Соёмбот хөшөө	5000	барилга байгууламж
13	Буянт	ЗДТГ	Ахмад дайчдын хөшөө	7,000.0	барилга байгууламж
НИЙТ ДҮН				172,550.0	

Булган сумын Нэгдсэн эмнэлэг, 2 дугаар сургууль, Зэрэг сумын ЕБС, Үенч сумын ЕБС, Цэцэг сумын Цэцэрлэг, Манхан сумын ЕБС, Цэцэрлэг зэрэг байгууллагууд гүний болон гар худаг ашиглаж байгаа ч данс бүртгэл тусгаагүй байна.

Орон нутгийн өмчийн газар нь хөрөнгө данс бүртгэлээс хасах тухай саналыг аймгийн ИТХ-д уламжлан шийдвэрлүүлээгүй байна.

1.3.3 ТБОНӨ-ийн тухай хуулийн 31 зүйлийн 31.3.1²⁵, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн “орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, данснаас хасах, тайлагнах” журамд зааснаар үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахдаа журмын 7.3.1-7.3.6 дах заалтын дагуу холбогдох баримтуудыг бүрдүүлэн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх ба уг саналыг хянан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрлүүлэхээр заасны дагуу 2020 онд 35 удаагийн тогтоолоор 767.5 сая төгрөгийн хөрөнгийг актлах, данс бүртгэлээс хасах тухай шийдвэр гаргажээ.

Орон нутгийн өмчийн газар нь эзэмшигч байгууллагаас санал хүсэлтийг ирүүлээгүй, хөрөнгө шилжүүлэх болон хасах тухай ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гараагүй байхад ялангуяа тээврийн хэрэгслийг худалдан борлуулах, дуудлага худалдаа зохион байгуулах тухай тогтоол шийдвэр гаргуулан борлуулдаг, данс бүртгэлээс хасах тухай тогтоолгүй, уг хөрөнгө нь бодитоор оршин байхгүй ч санхүүгийн тайлан балансад тусгасаар байгаа дутагдал нийтлэг байна. Тухайлбал: Чандмань сумын ЭМТ-ийн 2012 онд ашиглалтад орсон 19.0 сая төгрөгийн анхны өртөгтэй 1.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй УАЗ-469 автомашиныг 2018 оны аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 87 тоотор дуудлага худалдаанд оруулан зарагдсан ч холбогдох баримт материалыг аудитын явцад ирүүлээгүй болно.

Хүснэгт - 7

Д/д	Сум	Байгууллагын нэр	Тээврийн хэрэгслийн марк	Зарагдсан он	Балансын үнэ
1	Буянт	Засаг даргын тамгын газар	Пад	2015	1,910.0
2	Буянт	Засаг даргын тамгын газар	Ачааны машин	2015	6,700.0

²⁵ Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх

3	Буянт	Засаг даргын тамгын газар	Жийп	2019	30,000.0
4	Буянт	Эрүүл мэндийн төв	УАЗ-469	2020	19,677.0
5	Чандмань	ИТХ	УАЗ-469	2019	12,087.9
6	Чандмань	Эрүүл мэндийн төв	УАЗ-469	2018	19,031.1
7	Жаргалант	Хот тохижуулах газар	Ачааны машин	2020	8,302.8
8	Жаргалант	Эрүүл мэндийн газар	Ланд круйзер Прадо -76	2020	56,471.3
Нийт					154,180.1

БҮЛЭГ 2 ОРОН НУТГИЙН ӨМЧ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРГИЙГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

Хөрөнгийн тооллого хийсэн талаарх ажлын тайлангүй, үр дүн хангалтгүй байна.

2.1.1 Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолоор аймгуудын ЗДТГ-ын бүтэц орон тоог шинэчлэн баталсны дагуу Орон нутгийн өмчийн газрыг аймгийн Засаг даргын 2016 оны А/500 тоот захирамжаар 12 орон тоотойгоор Өмчийн алба, худалдан авах ажиллагаа гэсэн 2 албатай баталсан, 2020 оны А/873 тоот захирамжаар Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны алба болгон бүтцийг өөрчилснийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн албан бичгээр А/500 тоот захирамжийг мөрдөж ажиллахыг зөвлөжээ.

Аудитын явцад байгууллагын үйл ажиллагааны жилийн ажлын тайланг хянахад өмч хөрөнгийн нэгдсэн судалгаагүй, дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт хангалтгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70²⁶, 72²⁷, 73²⁸ дугаар зүйлд заасны дагуу байгууллагууд эд хөрөнгийн тооллогыг тухайн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр тооллогын комисс томилон тооллогыг явуулж хэвшсэн байна.

2.1.2 Аудитын явцад сумдад томилолтоор ажиллахад элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөнийг дахин үнэлээгүй, цаашид ашиглагдах боломжгүй болсон, нягтлан бодох бүртгэлд данс бүртгэлтэй боловч газар дээрээ оршин байхгүй байгаа зөрчил нийтлэг байна. Орон нутгийн

²⁶ Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа

²⁷ Тооллогын комисс, түүний эрх, үүрэг

²⁸ Эд хөрөнгийн тооллого явуулах журам

өмчийн газар болон сумдын өмч хамгаалах комиссын зүгээс ажил зохион байгуулж арга хэмжээ авалгүй олон жил тайланд тусгагдан өдий хүрчээ. Тухайлбал:

- Манхан сумын Засаг даргын тамгын газрын 17 төрлийн 450.7 сая төгрөгийн барилга байгууламж, 16 төрлийн 32.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 16 төрлийн 47.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл бүгд 49 нэр төрлийн 530.2 сая төгрөгийн хөрөнгө дансанд бүртгэлтэй ч ашиглах боломжгүй зарим тоног төхөөрөмжүүд бодитоор оршин байхгүй,
- Зэрэг сумын ЗДТГ-ын 5 төрлийн 3.3 сая төгрөгийн барилга байгууламж, 20 нэр төрлийн 5.8 сая тоног төхөөрөмж, нэг төрлийн 5 ширхэг 53.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл ашиглах боломжгүй,
- Зэрэг сумын Соёлын төвийн 2013 оны ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр гадна хашаа хийхэд 8.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдож одоо хүртэл хашаа баригдаагүй,
- Цэцэг сумын ЗДТГ-ын 6.0 сая төгрөгийн өртөгтэй нэг айлын орон сууцны 1990 оны барилгыг тодорхой бус шийдвэртэйгээр иргэн эзэмшиж байгаад өөр хүнд зарсан талаар маргаан үүссэн байдалтай хариуцах эзэнгүй хөрөнгө эзэнгүйдсэн,
- Цэцэг сумын ЕБС-ийн 5.0 сая төгрөгийн балансын үнэтэй зоорь, 0.4 сая төгрөгийн үнэтэй хүлэмжийн ашиглалт хангалтгүй, зоорь хүлэмжийг холбогдох байгууллагын шийдвэргүй буулгаж түүнээс гарсан материалуудыг сургуулийн хашаанд хураасан байдалтай,
- Чандмань сумын ЗДТГ-ын 3 нэр төрлийн 8.9 сая төгрөгийн барилга байгууламж, 7 нэрийн 7.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 3 нэрийн 2.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 16 нэр төрлийн 23.0 сая төгрөгийн программ хангамж, бусад үндсэн хөрөнгө /хадлангийн талбай, талбайн тор, хашаа, гудамжны гэрэлтүүлэг гэх мэт/ бүгд 30 нэр төрлийн 60.3 сая төгрөгийн хөрөнгө бодитоор оршин байхгүй,
- Манхан, Чандмань, Цэцэг, Зэрэг, Мөнххайрхан, Мянгад, Дэргэн сумдын ЭМТ-д 2018 онд ирсэн “Монгол улсын Засгийн газар”, БСШУЯ гэсэн хаягтай ямар зориулалтын тоног төхөөрөмж болох, хэдэн төгрөгийн үнэ өртөгтэй нь тодорхой бус, данс бүртгэлд тусгаагүй, Дарви сумын ЭМТ 1.2 сая төгрөгөөр бүртгэсэн,



2.1.3 Соёлын өв, үзмэрийн зүйлсийг түүвэрлэн тооллого хийхэд дараах байдалтай байна.

Тухайлбал:

- Манхан сумын Соёлын төвийн музейн бүртгэлд бүртгэгдээгүй, нягтлан бодох бүртгэлийн программд бүртгэлтэй, мөнгөн сүйх 1ш, мөнгөн дэгээ 1ш, мөнгөн дэнс 1ш, мөнгөн гуу 1ш, мөнгөн нүүртэй зүүвч 1ш бүгд 5 нэр төрлийн 133.6 /тэр үеийн ханшаар/ мянган төгрөгийн өв, үзмэрийн зүйлс бодитоор оршин байхгүй байна. Дээрх үзмэр, эд өлгийн зүйлсийг Сангийн сайдын 2013 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 140 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Түүх, соёл дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийн жагсаалтын 3.6 дах “гоёл чимэглэл”-ийн 3.6.2.9- зааснаар нэг бүр нь 800.0 мянган.төгрөг бүгд 4500.0 мянган төгрөгөөр үнэлэгдэхээр байна.

- Манхан сумын Соёлын төвд хадгалаастай байх өв, үзмэрийн бүртгэлд байгаа 1.5 сая төгрөгийн өртөгтэй уламжлагдан үлдээсэн архины “Вар”-ыг хагалж уг үзмэрийн чанар, агууламжийг алдагдуулсан,
- Мөст сумын сумын Соёлын төвд хадгалаастай байсан 0.5 сая төгрөгийн үнэтэй “Вар” нь хэзээ алга болсон нь тодорхой бус,
- Булган сумын Соёлын төвийн түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлс болох 3380.0 мянган төгрөгийн үүлэнцэр хөөрөг, хэтний тээг, гэртэй хутга, зэс бал, дугуй хаш, цахар хөөргөний шүрэн толгой зэрэг өв, үзмэрүүд алга болж холбогдох хариуцах эзэнгүй, жил бүрийн тооллого бодитой хийгээгүйгээс тайлан бүртгэлд тусгагдсаар байна.



Дээрх өв үзмэрийн зүйлсийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1²⁹, 26.2³⁰ дах заалтуудыг мөрдөөгүй байна.

ТБОНӨ-ийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1³¹, 72.4.4³²-д заасны дагуу зарим байгууллагууд тооллого хийдэггүй, тооллого хийхдээ хөрөнгө бүрийг нэг бүрчлэн нүд үзэж тоолдоггүйгээс хөрөнгө дутах, хэзээ алга болсон тодорхой бус, тооллого хийсэн тухай хурлын тэмдэглэл, тооллогын бүртгэлийн жагсаалт болон бусад холбогдох материалыг нягтлан бодогчид хүлээлгэн өгснийг нотлох анхан шатны баримтгүй, ажил хүлээлцэхдээ ажил хүлээлцсэн тухай акт, тэмдэглэл хөтөлдөггүйгээс тооллого үр дүнгүй, хөрөнгө дутах алга болсон зөрчил нийтлэг оршин байна. Үүнд:

- Зэрэг сумын ЕБС-ийн 5 ширхэг 2.2 сая төгрөгийн ленова маркийн зөөврийн компьютер 2020 оны 3 сард алдагдсан, 1.5 сая төгрөгийн sonu маркийн камер,
- Зэрэг сумын Хүүхдийн Цэцэрлэгийн 2002 онд сумын эмнэлгээс шилжиж ирсэн 0.5 сая төгрөгийн үнэтэй хонда мотор алга болсон,
- Цэцэг сумын ЭМТ-ийн эм зүйчийн 1.0 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер алдагдсан,
- Ховд сумын ИТХ-ын 7 нэр төрлийн 6.2 сая төгрөгийн зөөврийн компьютерыг тухайн үед ажиллаж байсан төлөөлөгч нар аваад буцаан өгөөгүй,
- Эрдэнэбүрэн сумын ЭМТ-ийн “усны чайн”-ыг холбогдох байгууллага албан тушаалтны шийдвэрлээгүйгээр хувь хүнд өгсөн,
- Чандмань сумын ЕБС-ийн 2012 оны 0.4 сая төгрөгийн зургийн аппарат нийт 11.9 сая төгрөгийн хөрөнгө хулгайд алдагдаж сумын Цагдаагийн хэсэгт өгсөн боловч өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүйтэй холбоотой төлбөрийн актыг тухайн байгууллагад хариуцахаар тогтоолоо.

Орон нутгийн байгууллагууд өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулаагүй, байгуулсан ч хийх ажлын төлөвлөгөөгүй байна.

²⁹ Соёлын биет бус өвийн үзлэгийг гурван жил тутамд, түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг таван жил тутамд, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг дөрвөн жил тутамд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна.

³⁰ Соёлын өвийг эзэмшигч нь тооллогоор илэрсэн зөрчлийг арилгах талаар тухайн шатны нутгийн захиргааны байгууллага болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран нэн даруй арга хэмжээ авна.

³¹ Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах,

³² Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх

2.1.5 Орон нутгийн өмчит байгууллагуудын “орон нутгийн өмчит этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”-ыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 94 дүгээр тогтоолоор батлагдаж журмын 1.2.1³³, 2.1.2³⁴ дах заалтын дагуу сумдын ИТХ, байгууллагуудын холбогдох албан тушаал шийдвэрээр “Өмч хамгаалах зөвлөл”-ийг томилсон байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журмыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор тус журмыг шинэчилсэн ч аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2017 онд батлагдсан өмнөх үлгэрчилсэн журмын дагуу боловсруулан баталсан журамд өнөөг хүртэл өөрчлөлт оруулаагүй байна.

Аудитын явцад Булган, Дөргөн, Чандмань, Буянт, Мөнххайрхан сумдын болон Цагдаагийн газар, ЭМГ, Зоониз өвчин судлалын төвийн өмч хамгаалах зөвлөл нь жилийн эцсийн тайлангаа нэгтгэн цахимаар ирүүлсэн. Дээрх сум байгууллагуудаас Мөнххайрхан, Дөргөн, Буянт сумд, Цагдаагийн газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа нь жигдэрч хэвшсэн байна.

Аудитаар түүвэрлэн 80 байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг цахимаар авч хянахад Манхан сумын ЗДТГ, Цэцэг сумын Цэцэрлэг, Манхан, Зэрэг сумдын ЭМТ, Сургууль, Жаргалант сумын 6 дугаар сургууль, 6 дугаар цэцэрлэг, аймгийн Насан туршийн боловсрол, Санхүү хяналт дотоод аудитын алба, Мянганд угалзат ОНӨААТҮГ зэрэг байгууллагууд өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулаагүй, 10 байгууллага нь 2017 оны журамтай нийцүүлэн өмч хамгаалах зөвлөлийг шинэчлээгүй, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 94 дүгээр тогтоолын 3.1³⁵ дэх заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

2.1.6 Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлыг дүгнэн аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх талаар журмын 1.3³⁶-д заасан түүвэрт хамрагдсан байгууллагын 36 байгууллага нь өмч хамгаалах зөвлөлийн ажлын тайланг ирүүлсэн, журмын 1.4³⁷, 1.6³⁸-д зааснаар өмч хамгаалах зөвлөлийн ажлыг нэгтгэн дүгнэсэн талаарх баримт материал ирүүлээгүй байна.

2.1.7 ТБОНӨ-ийн тухай хуулийн 77 дугаар 77.2.2³⁹-д зааснаар орон нутгийн өмчийн 2020 оны хөрөнгийн тооллогын нэгтгэлийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд оруулж хэлэлцүүлээгүй байна.

Орон нутгийн өмчийн газар нь хөрөнгийн нэгтгэлийг 1875.6 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэжээ.

2.2.1 Орон нутгийн өмч газар нь хөрөнгө нэгтгэхдээ Алтай сумын Цэцэрлэг, Мянганд сумын Соёлын төв, Жаргалант сумын Насан туршийн боловсрол хөрөнгийг 4292.0 сая төгрөгөөр илүү, Алтай сумын Шим ус, Булган сумын Насан туршийн боловсрол, Мөст сумын ЕБС,

³³ Сумдад харьяа байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийг 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сумын Төрийн сангийн төлөөлөгчийг оролцуулан сумын ИТХ-ын нарийн бичгийн даргаар ахлуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар байгуулна

³⁴ Орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага өмч хамгаалах байнгын зөвлөлийг 5 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй, тухайн байгууллагын дарга, эрхлэгч, захирлын шийдвэрээр байгуулна

³⁵ “зөвлөл нь улирал тутам нэгээс доошгүй удаа хуралдаж тухайн жилийн төлөвлөсөн ажлын хэрэгжилт сум байгууллагын өмч хөрөнгийн холбогдолтой бүхий л асуудлыг хэлэлцэж зөвлөмж дүгнэлт гаргах бөгөөд ажлын үр дүнгээ иргэд холбогдох байгууллагын хамт олонд мэдээлнэ”

³⁶ Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл нь үйл ажиллагаа хууль тогтоомж, зохих журмын хүрээнд өмчийн харилцааны талаар олгосон эрх хэмжээний дагуу явуулж хэрэгжүүлсэн ажлын дүнг сум өмч хамгаалах байнгын зөвлөл болон аймгийн Орон нутгийн өмчийн газарт жилийн эцсийн өмчин тайлантай хамт тайлагнана. Сумын өмч хамгаалах байнгын зөвлөл нь тухайн жилийн ажлын нэгдсэн тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлнэ.

³⁷ Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь сумдын болон байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн тухайн жилийн ажлын тайланг хүлээн авч нэгтгэн судалж тэргүүний зөвлөлийг шалгаруулан шагнаан урамшуулж ажлыг нь сурталчлан хүртээл болгоно

³⁸ Хариуцсан ажлыг үр бүтээлтэй хэрэгжүүлж амжилт гаргасан зөвлөлийг аймгийн Орон нутгийн өмчийн газраас түүнийг байгуулсан этгээдийн тодорхойлсноор урамшуулж шагнаж болно.

³⁹ Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчид, засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах гэрээг хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх ХОА-2021/118-ШТА-ГА/

Мянгад сумын Шим ус, Жаргалант сумын 6 дугаар сургууль, Жаргалант сумын 5 дугаар цэцэрлэг, Үенч сумын ЗДТГ, Үенч мөнх ундрах ОНӨТҮГ, Асрамжийн хороо, Булган сумын Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газрын хөрөнгийг 2416.4 сая төгрөгөөр дутуу буюу 1875.6 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэж ТӨБЗГ-т хүргэгдсэн байна. **Хүснэгт-8**

д/д	сум байгууллагын нэр	Аудитын нэгтгэл	Орон нутгийн өмчийн газрын нэгтгэсэн дүн	ЗӨРҮҮ	
				илүү	дутуу
1	Алтай сумын Цэцэрлэг	664.1	682.0	(17.9)	-
2	Алтайн Шим ус	2.3	-	-	2.3
3	Булган сумын Насан туршийн боловсрол	2.0	-	-	2.0
4	Мөст сумын ЕБС	2,522.6	2,473.4	-	49.2
5	Мянгад сумын Соёлын төв	1,004.0	1,009.0	(5.0)	-
6	Мянгад сумын Шим ус ОНӨТҮГ	3.1	-	-	3.1
7	Жаргалант сумын 6 дугаар Сургууль	2,518.1	2,517.9	-	0.2
8	Жаргалант сумын 5 дугаар Цэцэрлэг	863.5	861.1	-	2.4
9	Жаргалант сумын Насан туршийн боловсрол	46.7	4,315.8	(4,269.2)	-
10	Үенч сумын ЗДТГ	4,211.3	1,866.1	-	2,345.2
11	Үенч мөнх ундрах	5.0	-	-	5.0
12	Асрамжийн хороо	716.7	710.8	-	5.8
13	Булган сумын Нэгдсэн эмнэлэг	8,469.1	8,468.2	-	0.9
14	Эрүүл мэндийн газар	1,101.7	1,101.4	-	0.3
	НИЙТ ДҮН	22,130.1	24,005.8	(4,292.0)	2,416.4

2.2.2 2020 оны нэгтгэлд Алтай, Мянгад сумдын Шим ус ОНӨТҮГ, Булган сумын Насан туршийн боловсрол, Үенч сумын Мөнх ундрах ОНӨТҮГ-уудын 12.4 сая төгрөгийн хөрөнгө орхигдуулсан байна.

Хөрөнгийн цахим мэдээллийн систем ашиглагдах боломжгүй, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хийгдээгүй байна.

2.2.3 “Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн систем” -д орон нутгийн өмчийн байгууллагууд 2019 оны дуустал хугацаанд хөрөнгийн мэдээллийг бүрэн цахимжуулсан бөгөөд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын нэгдсэн системийн сервер нь УИХ-т байрладаг байсан бөгөөд 2020 онд гарсан гал түймэрт өртөж дахин ашиглах боломжгүй болсон байна.

2.3.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.¹⁴⁰-д заасны дагуу аймгийн ИТХ-аас 2016 онд ажлын хэсэг байгуулагдаж орон нутгийн өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын талаар өмчийн тооллого зохион байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 тогтоолын 8.4⁴¹ -д заасны дагуу Орон нутгийн өмчийн газарт үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн жилийн мэдээ тайлангаа орон нутгийн байгууллагууд ирүүлсэн байна.

Орон нутгийн өмчийн газрын 2020 онд хийсэн ажлын тайланд өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар хийсэн ажлын мэдээлэлгүй, аудитын явцад удаа дараа шаардсан боловч дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлсэнгүй.

⁴⁰ Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах

⁴¹ Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, акталж данснаас хассан эд хөрөнгийн хөдлөлийн нэгдсэн тайланг жил бүр эрх бүхий байгууллагаас баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн “үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн жилийн мэдээ” маягын дагуу гаргаж аймгийн Орон нутгийн өмчийн газар ирүүлнэ.

Тус газрын мэргэжилтнүүд 2019 онд Алтай, Булган, Үенч, Зэрэг, Дарви, Цэцэг, Мөст, Чандмань, Дарви, Дөргөн, Манхан, Мөнххайрхан сумдад хяналтаар ажиллахад сумдын байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь ажлаа жил улирлаар төлөвлөөгүй, биелэлтийг тооцоогүй хөрөнгө хадгалж буй агуулах склад нь стандарт шаардлагын дагуу тохижуулаагүй, хөрөнгө бүрийг коджуулж бүртгэлжүүлээгүй, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт, хувийн хэргийн хөтлөлт, баяжуулалт хийгээгүй зэрэг зөрчлүүдийг илрүүлсэн байна. Гэвч ОНӨГ-ын хэмжээнд хяналт шалгалтаар илрүүлсэн алдаа, зөрчил, зөвлөмжийг нэгтгэн дүгнэж албажуулсан мэдээ, тайлангүй байна.

Аудитаар нийт 6292.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 20.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 8.4 сая төгрөгийн зөрчил арилгуулж, сахилгын шийтгэл тооцуулах 3 албан шаардлага, 6263.4 сая төгрөгийн 17 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар аймгийн ИТХ, ЗД, Орон нутгийн өмчийн газрын даргад өгөгдлөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Өмч хөрөнгийн нэгдсэн судалгаагүй, хэрэгжүүлсэн ажлын тайлан хангалтгүй, ажлын хариуцлага сулаас өмчид тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ :

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ ТАНАА

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас баталсан тогтоол, журам зааврын дагуу орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой эрх зүйн актуудыг Аймгийн ИТХТ-ын хурлаар хэлэлцүүлэн шинэчлэн батлах
- Аймгийн Музей болон сумдын Соёлын төвийн өв, үзмэрийн зүйлийн хадгалалт, хамгаалалт, тэдгээрийн бүрэн бүтэн байдалд хяналт хэрэгжүүлэн үр дүнг тооцож ажиллах
- Сумдын ИТХ-д чиглэл хүргүүлэн орон нутгийн өмчийн ашиглалтад тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй зохион байгуулж ажиллах
- Өмч хөрөнгийн дуудлага худалдааг холбогдох хууль, журмын хүрээнд шударга, ил тод нээлттэй зохион байгуулах талаар онцгой анхаарч ажиллах,

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ ТАНАА

- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолыг мөрдөн Орон нутгийн өмчийн газрын орон тоо бүтэц зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх
- Аймгийн хэмжээний худгийн нэгдсэн тооллого хийж ашиглалтын байдлыг тогтоон, паспортжуулах
- Мөнххайрхан, Үенч, Манхан сумдын усан цахилгаан станцын тоног төхөөрөмжүүд бодитоор байгаа эсэхийг тогтоон тухайн барилга байгууламж бусад хөрөнгийн асуудлыг шийдвэр гарган цэгцлэх

- БИТ-ийн зориулалтаар баригдсан барилга байгууламж, халуун усны барилгын ашиглалтыг сайжруулах талаар сум орон нутгийн удирдлагуудыг үүрэг чиглэлээр хангаж гүйцэтгэлд нь хяналт тавих

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Ш.НОХОЙЖАВ ТАНАА

- Газрын мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтоор хүлээх үүргийг тодорхой болгож нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлэн ажиллах
- Байгууллагуудын өмч хадгалж буй агуулахыг стандарт шаардлагын дагуу тохижуулан, ашиглалтын явцад хийх үйлчилгээг хэвшүүлж, хадгалалт, хамгаалалт, аюулгүйн ажиллагааг бүрэн хангах арга хэмжээг авч ажиллах
- Анхны өртгөөрөө элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын байдал, хөрөнгийн ангиллыг тогтоон ангилж бүртгэлд үнэн бүртгэх
- Орон нутгийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг газрын хэмжээнд нэгтгэн дүгнэж хэвших
- ЭМГ-ын Прадо-76 таркийн тээврийн хэрэгслийн дуудлага худалдааг дахин ил тод нээлттэй зохион байгуулах
- Өмч хөрөнгийн тооллогыг бодитой үр дүнтэй хийх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах
- Түрээсийн гэрээний загвар маягыг үнэн зөв хөтлөх, түрээслэх талбайн хэмжээ болон хугацааг нарийн тусгах, төлбөрийн орлогын 30 хувийг сангийн дансанд бүрэн төвлөрүүлэх
- Дуудлага худалдааны орлогыг Төрийн сангийн дансанд төвлөрүүлэх, бэлнээр авч зарцуулдаг явдлыг таслан зогсоох
- Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэн ажиллах ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг тооцон 2021 оны 10 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэх

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ТАЙЛБАР:


**ХОВД АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР**
84140 Ховд, Ховд аймгийн Утас: 70434400
E-mail: Khovd@prosp.gov.mn

2021.07.07 № 72

тантай _____ -ны № _____ -т

Хүсэлт хүргүүлэх нь:

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай багууллагын 2021 оны 07 сарын 06-ний өдрийн 187 тоот албан бичгээр ирүүлсэн "Орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.


Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалтын талаар манай байгууллага удаа дараа сум байгууллагуудад өмч, хөрөнгийн талаар сургалт семинар зохион байгуулах, Засаг даргаар удирдамж батлуулан ажиллах, зөвлөмж хүргүүлэх, зэрэг ажлыг хийж ажиллаж байгаа хэдий ч сум, байгууллагын ажил хариуцсан дарга, удирдлага холбогдох мэргэжилтэнүүдийн ажлын хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж хөрөнгийн ашиглалт хамгаалалт үр дүнгүй болох, хөрөнгийн ашиглалтын талаархи санал хүсэлтээ өмчийн байгууллагад ирүүлдэггүй зэрэг зөрчил дутагдал байсаар байна. Мөн 2020 оны хөрөнгийн нэгтгэлийн хувьд Аудитын байгууллагаас нягтлан шалгагдаж аудитлагдсан тайланг авсан. Сум байгууллагын ажил хариуцсан нягтлан бодогч нарын хариуцлагагүй хэнэггүй байдлаас болж хөрөнгийн бүртгэл, тайлан мэдээ зөрүүтэй бүртгэгдсэн байхыг үгүйсгэхгүй. Алтай сумын "Шим-Ус", Булган сумын Насан туршийн боловсрол, "Мянгад Шим-Ус ОНӨТҮГ", Үенч Мөнх-Ундрага ОНӨТҮГ газар зэрэг байгууллагууд нь идэвхитэй үйл ажиллагаа явуулдаггүй үйл ажиллагаа нь жигдрээгүй зэрэг шалтгаанаас Орон нутгийн өмчийн газарт тайлангаа өгдөггүй.

Буянт сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Чандмань сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Жаргалант сумын хот тохижуулах газар, аймгийн Эрүүл мэндийн төв зэрэг 3 сумын 8 байгууллагын автомашины дуудлагын худалдааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан. Холбогдох материалыг танай байгууллагад хүргүүлэн ажиллана. Цагдаагийн газрын төв захын доод талд байрлах кобаны дуудлагын худалдааг Цагдаагийн газар нь өөрөө зохион байгуулсан.

Та бүхний хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж үүрэг даалгаварыг цаашдын ажлын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах болно.

Хууль хяналтын байгууллагатай холбоотой зүйл заалтыг хасаж өгөхийг хүсье.

ДАРГА  Ш.НОХОЙЖАВ


Хууль, зуримын
дагуу шалгалт хийж,
Х.Балар

ХОВД АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР

84140 Ховд, Ховд аймаг Утас: 70434400



E-mail: Khovd@pcsp.gov.mn

2021.07.08 № 75
танай _____ -ны № _____ -т

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Х.БОЛДБААТАР ТАНАА

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 115, 215 дугаар тогтоолоор дуудлагын худалдаагаар худалдан борлуулахаар зарласан аймгийн Эрүүл мэндийн газрын Ланд круйзер-76 маркийн 4463 УНЛ улсын дугаартай тээврийн хэрэгсэлийн дуудлагын худалдааг дахин зарлан явуулах боломжтой .

ДАРГА  Ш.НОХОЙЖАВ



2021.07.08



САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

д/д	ирүүлсэн санал, тайлбарын утга	шийдвэрлэлт
1	Цагдаагийн газрын төв захын доод талд байрлах кобины дуудлага худалдааг Цагдаагийн газар өөрөө зохион байгуулсан	Цагдаагийн газрын санхүүгийн албаны даргатай холбогдож холбогдох баримт материалыг албан тоотоор ирүүлэх болсон
2	Чандмань сумын ЭМТ-ийн УАЗ-469 дугаартай автомашины талаар мэдээллийг 74 тоот албан тоотоор хавсарган ирүүлсэн	Аудитын тайлангийн 1.3.3-д асуудлыг тусгагдсан зөвлөмж өгөгдсөн.
3	ЭМГ-ын Прадо76 автомашиныг дуудлага худалдаа зохион байгуулсан асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэхгүй байх	Орон нутгийн өмчийн газарт албан шаардлага хүргүүлэх хэрэгжүүлээгүй тохиодолд хууль хяналтын байгууллагад уламжлах нь зүйтэй

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР